



**НОГООН ХӨГЖИЛ  
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ**  
ХУВЬЦААТ КОМПАНИ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ**

**2022.12.22**



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дүгээр  
сарын 22-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТУХАЙ**

**Компанийн тухай хуулийн 61.1.5, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн дүрмийн 6.3 заалт үндэслэн ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайланд хариу тайлбар хүргүүлэх, Компанийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг оновчтой зохион байгуулж хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх талаарх асуудлыг ажлын хэсэг байгуулан холбогдох арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Санжаа/-д даалгасугай.
2. ТУЗ-ын дэргэдэх дэд хороод шуурхай хуралдаж компанийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг оновчтой зохион байгуулж хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх талаарх ажлын хэсгийн саналыг хэлэлцэн, дэмжиж гүйцэтгэх удирлагатай хамтран ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын хурлыг 2022 оны 12-р сарын 29-ны өдрийн ээлжит хурлаар ажлын хэсгээс гарсан саналыг хэлэлцүүлэхийг ТУЗ-ын дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгасугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 1 дугаар сарын 31 – ны өдөр зарлан хуралдуулах гүйцэтгэх захирал /Д.Санжаа/-д үүрэг болгосугай.

5. Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар 2023 оны 01-р сарын 31-ны өдрийн ТУЗ-ын хурлаас гарах санал, дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг ТУЗ-ын дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дүгээр  
сарын 22-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх хяналт тавих” журам, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн дүрмийн 7.3 дах заалт тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цагт хуралдуулахаар тогтсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Хан-Уул дүүрэг 15-р хороо ЭЛ-ЭС плазагийн 11 давхарт 1102 тоотод зохион байгуулж холбогдох зардалыг гүйцэтгэх захирал /Д.Санжаа/ хариуцан ажилласугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр зайнаас оролцох боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгож ажиллахыг /Д.Санжаа/-д даалгасугай.
4. Тус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
  1. ТУЗ-ын үйл ажиллагааны журам
  2. Хувьцаа хуваах тухай
  3. Нэмэлт хувьцаа гаргах тухай
  4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
  5. Төсөл, хөтөлбөрүүдийг оновчтой зохион байгуулах талаарх ТУЗ-аас гаргасан саналыг хэлэлцэх, шийдвэрлэх тухай.
  6. ТУЗ-ын зардлыг батлах тухай

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 1 дүгээр сарын 20 – ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
6. Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ний хувьцаа эзэмшигчийн анхааралд хавсралт №1, ээлжит бус хурлыг дэгийг хавсралт №2, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг хавсралт №3, ээлжит бус хуралд санал авах хуудсыг хавсралт №4-өөр тус тус баталсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 1 дугаар сарын 31 – ний өдөр зарлан хуралдуулахыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлаарх санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгосугай.
9. Хурлын үед ажиллах тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
  1. М.Отгонбаатар /дарга/
  2. Ш.Нарангаравуу
  3. Э.НямгарамЭэлжит бус хурлын санал авах үйл явцтай холбогдол бүхий баримт бичгүүдийг боловсруулах, баталгаажуулах, санал авах үйл явцыг зохих журмын зохион байгуулахыг тооллогын комисс /М.Отгонбаатар/-т даалгасугай.
10. Ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал /Д.Санжаа/, ерөнхий нягтлан бодогч /Т.Ганчимэг/, хуульч /Т.Отгонтамир/ нарыг тус тус томилсугай.
11. Хурлаар хэлэлцүүлэх баримт, бичгүүдийг нэг бүрчлэн нягталж зар хүргэх сувгуудад байршуулах ажлыг зохион байгуулах хороонд үүрэг болгосугай.
12. Ээлжит бус хурлыг зайнаас цахим хэлбэрээр зохион байуулах, удирдах, асуулт хариултыг зохион байгуулахыг техникч /Э.Бат-Амгалан/-д даалгасугай.
13. Хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг гаргахыг ерөнхий нягтлан /Ганчимэг/-д зөвшөөрсүгэй.

14. Ээлжит бус хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио телевизээр 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр, давтамж зарыг 1 дүгээр сарын 15-ний өдөр багтаан мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргэж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, танилцуулга бэлдэх, хурлаас гарах шийдвэр бусад холбогдох бичиг баримтуудыг боловсруулах, зар хүргэх асуудлуудыг тус тус зохион байгуулахыг комиссын дарга, гүйцэтгэх захирал /Д.Санжаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөр тооцно.

**Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.**

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2. Хувьцаа хуваах тухай
3. Нэмэлт хувьцаа гаргах тухай
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Төсөл, хөтөлбөрүүдийг оновчтой зохион байгуулах талаарх ТУЗ-аас гаргасан саналыг хэлэлцэх, шийдвэрлэх тухай
6. ТУЗ-ийн зардлыг батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК /ҮЦК/ дээр ажлын өдрүүдэд /даваа-баасан/ 09:00-16:00 цаг хүртэл авах боломжтой ба “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн пейж хуудсаар нээлттэй хэлэлцүүлэгт оролцох боломжтой болно.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас:

Д.Санжаа 9952-4524 М.Отгонбаатар 9191-8840, Э.Нямгарам 8090-7722

Имэйл хаяг: [Maanaa8bhu@gmail.com](mailto:Maanaa8bhu@gmail.com). [Nhun.jsc@gmail.com](mailto:Nhun.jsc@gmail.com)

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэлх хугацаанд **“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн веб сайтад хуудсаар** нээлттэй өргөн хэлэлцүүлэг явуулан хуралдуулахаар төгтлөө.

№	Агуулга	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэн гаргах /комисс/	2023.01.31 15:00 цаг
2	Хурлаар хэлэлцэх үндсэн асуудлуудыг веб сайтад хуудсанд байрлуулах	
3	Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт, хариулт	Онлайнаар, танхим
4	Хэлэлцсэн асуудлын талаар санал гаргах	Онлайнаар, танхим
5	Санал хураалт	Тооллогын комисс
6	Хурлаас гарах шийдвэрийн тогтоолын төслийг танилцуулах	Хурлын дарга, тооллогын комисс. Мөн өдөртөө.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**





## **“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн стратегийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- Компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоол болон хавсралтууд
  - ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
  - Хувьцаа хуваах тухай
  - Нэмэлт хувьцаа гаргах тухай
  - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
  - Төсөл, хөтөлбөрүүдийг оновчтой зохион байгуулах талаарх ТУЗ-аас гаргасан саналыг хэлэлцэх, шийдвэрлэх тухай
  - ТУЗ-ийн зардлыг батлах тухай
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар
- Ээлжит хурал зарласантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр .....  
Хувьцаа эзэмшигчдийн регистрийн дугаар.....  
Эзэмшиж буй хувьцааны тоо.....  
Бүртгэсэн үнэт цаасны компанийн нэр.....  
Брокерийн овог.....Нэр.....

1."Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хүртэлх хугацаанд "Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК-ийн Веб сайт, танхимийн хурлыг хослуулан нээлттэй өргөн хэлэлцүүлэг явуулан хуралдуулахаар тогтлоо.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	ТУЗ-ын үйл ажиллагааны журам батлах тухай			
2	Хувьцаа хуваах тухай			
3	Нэмэлт хувьцаа гаргах тухай			
4	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай			
5	Төсөл, хөтөлбөрүүдийг оновчтой зохион байгуулах талаарх ТУЗ-аас гаргасан саналыг хэлэлцэх, шийдвэрлэх тухай			
6	ТУЗ-ын зардлыг батлах тухай			

Брокер/...../Гарын үсэг

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч/...../Гарын үсэг

2023 оны ..... сар .....өдөр

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ  
ХУВЬЦААТ КОМПАНИ  
2051834 9022040414 СБТ 18537

Компанийн нэр	“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК
Хаяг, Утас	Улаанбаатар хот
Хурал хуралдах өдөр цаг	2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр, 15:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	УБ хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Эл-Эс Плаза, 1102 тоот
Хурлын төрөл	Ээлжит бус
Хурал зарлагч	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр
Олон нийтэд зарласан огноо	202. оны .. дугаар сарын ..-ны өдөр
Бүртгэлийн өдөр	202. оны .. дугаар сарын ..-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер диллерийн компанид хүргүүлэх огноо	202. оны .. дугаар сарын ..-с ..-ний хооронд
Хүргүүлсэн огноо	202. оны .. дугаар сарын ..-ны өдөр
Хурлын дарга нэр	Ж.Жаргалсайхан
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	М.Отгонбаатар, Ш.Нарангаравуу, Э.Нямгарам
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/	Албан бичиг, тогтоол, хавсралт, бусад
Баримт бичгийн хуудасны тоо	.....ширхэг .....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... Д.САНЖАА

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр